

## МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨГӨХ САНАЛ, ШҮҮМЖ-2

### ШҮҮГЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ, ТОМИЛГОО

*2019 оны 11 сарын 14-д батлагдсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хэрэгжилтийг хангах үүднээс холбогдох хууль тогтоомжийг нийцүүлэн өөрчлөх хэрэгцээ шаардлага үүсэж байна. Нэмэлт, өөрчлөлтийн нэг томоохон хэсэг нь шүүх эрх мэдлийг бэхжүүлэхэд чиглэсэн гурван заалт бөгөөд энэ хүрээнд шүүхийн тухай хууль тогтоомжид өөрчлөлт орох юм.*

*2020 оны 1 сарын 31-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны цахим хуудсанд Шүүхийн тухай хуулийн төсөл, танилцуулга, үзэл баримтлалын хамт нийтлэгдэж олон нийтийн саналыг авч эхлээд байна. Нээлттэй Нийгэм Форумын Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд энэхүү чухал бодлогын баримт бичигт ул суурьтай, судалгаанд суурилсан санал шүүмж өгөх нь зүйтэй гэж үзлээ. Энэ зорилгоор шүүх эрх мэдлийн хүрээнд бодлогын судалгаа хийж байсан туршилагатай хуульч, судлаачдын төлөөлөлтэй зөвлөлдөж, холбогдох харьцуулсан судалгаа, дүн шинжилгээний дүнд үндэслэн энэхүү хуулийн шүүмжийг боловсруулан гаргалаа.*

*Шүүхийн тухай хуулийн төсөл нь одоогийн үйлчилж буй Шүүхийн тухай, Шүүхийн захиргааны тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай болон Шүүхийн иргэний төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулиудыг нэгтгэн багтааж боловсруулагдсан тул өргөн хүрээний агуулгыг хамарсан болно. Иймээс энэхүү хуулийн шүүмжийг Шүүхийн тухай хуулийн үзэл баримтлал, Шүүгчийн сонгон шалгаруулалт томилгоо, Шүүхийн ерөнхий зөвлөл гэсэн тодорхой сэдвийн хүрээнд цувралаар гаргаж бодлого боловсруулагчдын анхааралд хүргэхийг зорилоо.*

### ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ШҮҮГЧИЙН ТОМИЛГООТОЙ ХОЛБОГДОХ ХЭСЭГТ ӨГӨХ САНАЛ, ШҮҮМЖ

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд боловсруулсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн төслийн 7-12 дугаар бүлэгт одоо дагаж мөрдөж байгаа Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зохицуулалтын

агуулгыг тусгажээ. Одоо үйлчилж буй хууль болон Шүүхийн тухай хуулийн төслийн зохицуулалтыг харьцуулан дүн шинжилгээ хийсний дүнд дараах санал, шүүмжийг өгч байна.

## Нэг. ШҮҮГЧИД ТАВИХ БОЛЗОЛ, ШААРДЛАГА

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль	Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн төсөл
<p>4.1. Шүүгч нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан болзол болон дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>4.1.1. ял шийтгүүлж байгаагүй;</p> <p>4.1.2. шүүгчид нэр дэвших үед гэмт хэрэгт холбогдоогүй буюу сэжигтэн, яллагдагчаар татагдаагүй, бусдад хугацаа хэтэрсэн зээлийн өргүй;</p> <p>4.1.3. шүүгчээр ажиллахад харшлах өвчин, сэтгэцийн эмгэггүй;</p> <p>4.1.4. хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан;</p> <p>4.1.5. мэргэжлийн ёс зүйгээ ухамсарласан, шударга ёсыг эрхэмлэдэг, хүний эрхийг дээдлэх, бусдын нөлөөнд автахгүй, бие даасан шийдвэр гаргах чадвартай;</p> <p>4.1.6. монгол хэлний ярианы болон бичгийн соёл, чадвартай;</p> <p>4.1.7. мэдээллийн технологийн хэрэглээний программыг ашиглах чадвартай;</p> <p>4.1.8. шүүгчээр ажиллах тухайн дагнасан шүүхийн салбар эрх зүйн мэдлэг, туршлагатай;</p> <p>4.1.9. бусдын саналд хүндэтгэлтэй хандаж, шүүмжлэлийг бодитойгоор хүлээн авч, өөрийн байр суурийг ойлгомжтой тайлбарлах зэрэг асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай зан чанартай байх.</p>	<p>34.1. Шүүгч нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан болзол болон дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>34.1.1. эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй;</p> <p>34.1.2. шүүгчид нэр дэвших үед гэмт хэрэгт холбогдоогүй буюу эрүүгийн хэрэг үүсгэгдэж, яллагдагчаар татагдаагүй;</p> <p>34.1.3. шүүгчээр ажиллахад харшлах өвчин, сэтгэцийн эмгэггүй болохыг тогтоосон эрх бүхий эмнэлгийн мэргэшсэн эмчийн магадалгаатай байх;</p> <p>34.1.4. хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх.</p>

Дагаж мөрдөж байгаа Шүүгчийн эрх зүйн байдлын хуулийн мөн §4.1.5-4.1.9-д заасан шүүгчид тавигдах шаардлагуудыг хуулийн төсөлд тусгаагүй, харин “Мэргэшлийн хорооны үнэлгээ” гэсэн 88 дугаар зүйлийн §88.2-т “Суурь шалгалт нь монгол хэлний бичгийн болон ярианы чадвар, Үндсэн хуулийн болон салбар эрх зүйн мэдлэг, мэдээллийн технологийн хэрэглээний программ ашиглах чадвар, эрх зүйн баримт бичгийн боловсруулалт, хууль хэрэглэх ур чадвараас бүрдэнэ”, §88.3-т “Тусгай шалгалт нь хувь хүний зан төлөв, ёс зүй, нэр хүндийн байдал, Үндсэн хуулийн болон салбар эрх зүйн мэдлэг, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх чадвар, хуульчийн болон шүүгчийн ёс зүйн байдал, хууль тайлбарлан хэрэглэж эрх зүйн дүгнэлт өгөх чадвар, шүүн таслах ажиллагааны туршлага, удирдан зохион байгуулах ур чадвар зэргээс бүрдэнэ” гэж тусгажээ.

Энэ шалгуурыг зөвхөн Мэргэшлийн хороо л шалгалтын явцад шалгах, үнэлгээ өгөхдөө харгалзах байдлаар төсөлд тусгасан нь хэт явцууруулжээ. Хуулийн төслийн §88.2, §88.3-т заасан шалгуурыг шүүгчид тавигдах, болзол шаардлага хэсэгт тусгах нь зүйтэй. Ингэснээр Мэргэшлийн хороо төдийгүй ШЕЗ-ийн зүгээс холбогдох шийдвэрүүдээ гаргахад уг болзол, шаардлагад тулгуурлах боломжтой болно.

Хуулийн төсөлд дагаж мөрдөж байгаа Шүүгчийн эрх зүйн байдлын хуулийн §4.1.2-т заасан “бусдад хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх” гэсэн олон улсад хэрэгждэг шаардлагыг хассан нь ойлгомжгүй байна. Бусдад хугацаа хэтэрсэн зээлийн өртэй байх нь тухайн нэр дэвшигчийн хувийн хариуцлага сул байгаагийн нэг илэрхийлэл бөгөөд ийм хүнийг шүүгчээр томилбол шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг дааж чадах эсэхэд эргэлзээ үүсэх үндэслэл мөн юм.

**Санал:** Бусад хуулийн зохицуулалтаас үзэхэд 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн §29.3.2-т зааснаар нэр дэвшигчид “татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх, аль нэг компанийн 51, түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшдэг бол тухайн компани нь албан татварын хугацаа хэтэрсэн өргүй байх”<sup>1</sup>, Банкны тухай хуулийн §32.1.1-д “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд “зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй” байх зэргээр цөөнгүй хууль болон бусад дүрэм журмаар уг шаардлагыг холбогдох этгээдэд тавьсан байдаг зэргийг харгалзан “бусдад хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх” гэсэн шаардлагыг илүү дэлгэрүүлж (зөвхөн зээлээр хязгаарлахгүй) боловсронгуй болгох.

Хуулийн төслийн §34.1.2-т заасан зохицуулалт нь дагаж мөрдөж буй Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн §4.1.2 дахь заалтыг илүү тодорхой болгосон буюу гэмт хэрэгт холбогдоогүй гэдэг нь “эрүүгийн хэрэгт яллагдагчаар татагдаагүй байх” гэсэн утгыг агуулж байгааг тодотгосон нь сайшаалтай ч заавал “буюу” холбоосыг оруулах шаардлага байгаа эсэхийг анхаарах шаардлагатай. Учир нь өнөөдөр Монгол Улсын хууль зүйн салбарт “буюу” холбоосыг “эсхүл” гэдэгтэй утга нэг гэж тайлбарлаж хэрэглэх (ийнхүү ойлгож хуульчлах) тохиолдол гардаг нь хуулийг нэг мөр ойлгоход бэрхшээл учруулдаг. Өөрөөр хэлбэл, “гэмт хэрэгт холбогдоогүй” гэдгийг “эрүүгийн хэрэг үүсгэгдэж, яллагдагчаар татагдаагүй” гэдгээс салгаж тайлбарлах эрсдэлийг бий болгож болзошгүй.

**Санал:** Иймд хуулийн төслийн §34.1.2 дахь заалтыг “шүүгчид нэр дэвших үедээ эрүүгийн хэрэгт яллагдагчаар татагдаагүй байх” гэж өөрчлөх.

## А. Давж заалдах шатны шүүхийн шүүгчид тавих болзол, шаардлага

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль	Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн төсөл
<p>5.1. Давж заалдах шатны шүүхийн шүүгч энэ хуулийн 4.1-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:</p> <p>5.1.1. анхан шатны шүүхэд шүүгчээр гурваас доошгүй жил ажилласан, шүүн таслах ажиллагааны туршлагатай;</p> <p>5.1.2. шийдвэрлэсэн хэргийн хүрээнд судалгаа, дүгнэлт хийх чадвартай;</p> <p>5.1.3. мэргэшсэн чиглэлээр хэрэглэгддэг хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал гаргах, хуулийн зүйл, заалтыг зөв хэрэглэх талаар мэргэжлийн хэвлэлд өгүүлэл бичин, нийтлүүлсэн байх.</p>	<p>34.3. Давж заалдах шатны шүүхийн шүүгч энэ хуулийн 34.1-д зааснаас гадна анхан шатны шүүхэд шүүгчээр зургаагаас доошгүй жил ажилласан байна.</p>

<sup>1</sup> 2015 оны Сонгуулийн тухай хуульд ч нэр дэвшигчид ийм шаардлага тавьсан байсан.

Өнөөдөр манай улс шүүхийг хэрэг, маргааны төрлөөр дагнан байгуулах хандлагад нэгэнт шилжсэн. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр шүүхийг тойргийн журмаар хэрэг, маргааны төрлөөр дагнан байгуулах эрх зүйн үндсийг тогтоосон ба энэ хүрээнд зөвхөн нийслэлд бус орон нутагт эрүү, иргэний хэргийн төрлөөр давж заалдах шатны шүүхийг дагнан байгуулах бүрэн боломжтой болсон. Гэхдээ шүүхийг хэрэг, маргааны төрлөөр дагнуулж байгуулаад зогсохгүй, уг шүүхийн шүүгчээр тухайн хэрэг, маргааны төрлөөр дагнаж мэргэшсэн хүн томилогддог байж гэмээ нь дагнасан шүүхийн тогтолцоо бодитоор (de facto) бий болно.

**Санал:** Иймд хуулийн төсөлд давж заалдах шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигч нь тухайн дагнасан анхан шатны шүүхэд ажилласан байх шаардлагыг тодруулан тусгах.

Дагаж мөрдөж байгаа Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн §5.1.3-т заасан “шаардлага нь давж заалдах шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх бодитой шаардлага болж чаддаггүй, хэлбэрийн төдий шаардлага тул үүнийг хуулийн төсөлд тусгаагүйг дэмжиж байна. Харин Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн §5.1.2-т заасан шаардлагыг хэвээр хадгалах нь зүйтэй.

## Б. Хяналтын шатны шүүхийн шүүгчид тавих болзол, шаардлага

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль	Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн төсөл
<p>6.1. Хяналтын шатны шүүхийн шүүгч буюу Улсын дээд шүүхийн шүүгч энэ хуулийн 4 дүгээр зүйлд зааснаас гадна дор дурдсан нэг буюу түүнээс дээш шаардлагыг хангасан байна:</p> <p>6.1.1. давж заалдах шатны шүүхэд таваас доошгүй жил ажилласан;</p> <p>6.1.2. өмгөөлөгч, шүүгч, прокуророор арваас доошгүй жил ажилласан;</p> <p>6.1.3. Хуульчдын холбооноос магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн сургуульд арваас доошгүй жил багшилсан;</p> <p>6.2. Улсын дээд шүүхийн шүүгчээр сүүлийн зургаан жилд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, улс төрийн намын дарга, удирдах албан тушаал хашиж байсан хүнийг томилохыг хориглоно.</p>	<p>34.3. Улсын дээд шүүхийн шүүгч Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан болзол болон энэ хуулийн 34.1-д зааснаас гадна доор дурдсан шаардлагыг хангасан байна:</p> <p>34.4.1. анхан шатны шүүхэд шүүгчээр арван жил ажилласан, эсхүл давж заалдах шатны шүүхэд таваас доошгүй жил ажилласан;</p> <p>34.4.2. өмгөөлөгч, прокуророор арваас доошгүй жил ажилласан.</p> <p>34.5. Улсын дээд шүүхийн шүүгчээр сүүлийн зургаан жилд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Дэд сайд, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын удирдлага, бүх шатны Засаг дарга, улс төрийн намын дарга, удирдах албан тушаал хашиж байсан хүнийг томилохыг хориглоно.</p>

Төслийн 34.5-д Улсын дээд шүүхийн шүүгчээр сүүлийн зургаан жилд дурдсан улс төрийн албан тушаал хашиж байсан хүнийг томилохыг хориглосон нь уг шүүх дэх улс төрийн нөлөөллийг саармагжуулж бие даан ажиллах нөхцөлөөр хангахад чиглэсэн сайшаалтай заалт болжээ. Гэвч хуулийн төсөлд Улсын дээд шүүхийн шүүгчид тавигдах шаардлагаас дагаж мөрдөж байгаа Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн §6.1.3 дахь заалтыг хасжээ. Улсын дээд шүүх буюу хяналтын шатны шүүх зөвхөн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх чиг үүрэгтэй тул уг шүүхийн бүрэлдэхүүний дийлэнхийг шүүгчийн ажлын туршлагатай хуульчид бүрдүүлэхийн зэрэгцээ өмгөөлөгч, прокурор, хууль зүйн сургуулийн багш зэрэг хууль зүйн ажлын тал бүрийн туршлагатай хуульчдыг оруулах боломжтой байх нь хуулийг олон талаас харж илүү үндэслэлтэй тайлбарлах, эрх зүйг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтойд тооцогддог. Жишээлбэл, Японы Дээд шүүх Ерөнхий шүүгч болон 12 шүүгчээс бүрдэх бөгөөд эдний 5 нь шүүгчийн, 4 нь өмгөөлөгчийн, 2 нь прокурорын, 1 нь их сургуулийн профессорын, 1 нь төрийн захиргааны албан хаагчийн ажлыг Дээд шүүхэд томилогдохоосоо өмнө хийж байжээ. Францын Дээд шүүхийн шүүгчдийн дийлэнхийг шүүгчдээс бүрдүүлдэг ч зарим нь хуулийн профессор, хуульчид байдаг.<sup>2</sup> Иймд, Монгол Улсын дээд шүүхэд тодорхой хугацаанд хууль зүйн сургуульд багшаар ажиллаж байгаа хүн томилогдох боломжтой байх нь зүйтэй.

**Санал:** Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчид тавигдах Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн §6.1.3-т заасан шалгуурыг хэвээр үлдээх, ингэхдээ уг шаардлагыг илүү боловсронгуй болгож “хууль зүйн докторын зэрэгтэй” байх гэсэн шаардлагыг хуулийн төсөлд тусгах.

## Хоёр. ШҮҮГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль	Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн төсөл
<p>13.2. Шүүхийн ерөнхий зөвлөл нь энэ хуулийн 13.1-д заасан<sup>3</sup> дүгнэлт, Шүүхийн мэргэшлийн хорооны үнэлгээ болон энэ хуулийн 12.2-т заасан<sup>4</sup> Хуульчдын холбооны дүгнэлтийн хамт шүүгчийн албан тушаалд томилуулах нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтыг үнэлгээний дүнгээр эрэмбэлж гарган, илээр санал хураан олонхын санал авсан хүний нэрийг ажлын таван өдрийн дотор Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.</p>	<p>36.1. Шүүхийн ерөнхий зөвлөл нь Мэргэшлийн хорооны үнэлгээг үндэслэн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилуулах нэр дэвшигчээс илээр санал хурааж, олонхын санал авсан хүнийг шүүгч, Ерөнхий шүүгчээр томилуулахаар ажлын таван өдрийн дотор Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.</p>

<sup>2</sup> [https://www.courdecassation.fr/about\\_the\\_court\\_9256.html](https://www.courdecassation.fr/about_the_court_9256.html)

<sup>3</sup> Шүүхийн ерөнхий зөвлөл нь энэ хуулийн 11.2-т заасан баримт бичиг, энэ хуулийн 11.6-д заасан мэдээллийг судлан үзэж, нэр дэвшигч бүртэй ганцаарчилсан ярилцлага зохион байгуулж дүгнэлт гаргана.

<sup>4</sup> Хуульчдын холбоо нэр дэвшигчийн мэргэшил, ур чадвар, нэр хүндийн талаарх дүгнэлтийг Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлнэ.

Хуулийн төслийн §88.5-д “Анхан шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн мэргэшил, ур чадвар, нэр хүндийн талаарх дүгнэлтийг Ерөнхий зөвлөлд 7 хоногийн дотор хүргүүлнэ. Нэр дэвшигчийн мэргэшил, ур чадвар, нэр хүндийн талаарх дүгнэлт гаргах журмыг Ерөнхий зөвлөл батална” гэж тусгасан ч уг дүгнэлт нь хаанаас гаргасан дүгнэлт байхыг тодорхой заагаагүй (санамсаргүйгээр Монголын Хуульчдын холбоо гэдгийг орхигдуулсан уу) байна.

Монголын Хуульчдын холбооны шүүгчид нэр дэвшигчийн мэргэшил, ур чадвар, нэр хүндийн талаар дүгнэлт гаргах процесс, дүгнэлт гаргах шалгуур, үзүүлэлтийг сайжруулж, хөгжүүлэх шаардлагатай байгаа ч энэхүү дүгнэлт нь шүүгчийн сонгон шалгаруулалтад шаардлагагүй зүйл биш юм. Цаашид Монголын Хуульчдын холбооны энэхүү дүгнэлт гаргах процесс, шалгуур, үзүүлэлтийг илүү сайжруулж шүүгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд ашигласнаар хамгийн сайн ур чадвар, мэдлэгтэй, ёс зүйтэй хүнийг шүүгч болгоход ач холбогдолтой. Аливаа хуульч нь шүүгчээр ажиллах өндөр болзол, шаардлагыг хангасан эсэхийг бусад нь илүү сайн мэддэг учраас бүх хуульчийг заавал гишүүнчлэлээр нэгтгэсэн Хуульчдын холбооноос зохих журмын дагуу дүгнэлт гаргах нь тухайн нэр дэвшигчийг бодитой үнэлэхэд туслах бие даасан нэгэн суваг юм. Ийм чиг үүргийг Америкийн хуульчдын холбоо зэрэг бусад улсын хуульчдын холбоод хэрэгжүүлдэг бөгөөд харьцуулсан судалгаагаар сайн туршлагад тооцогддог билээ.

**Санал:** Иймд Монголын Хуульчдын холбооны шүүгчид нэр дэвшигчийн мэргэшил, ур чадвар, нэр хүндийн талаар дүгнэлт гаргадаг одоогийн зохицуулалтыг хэвээр хадгалах.

## **А. Шүүгчийн сонгон шалгаруулах ажиллагаанд Шүүхийн ерөнхий зөвлөлийн оролцоог тодорхой болгох**

Өнгөрсөн хугацаанд байнга гарч байгаа шүүмжлэл бол Шүүхийн мэргэшлийн хорооны үнэлгээг давсан нэр дэвшигчдээс Шүүхийн ерөнхий зөвлөлийн нэг нэр дэвшигчийг сонгож Ерөнхийлөгчид өргөн мэдүүлж байгаа үндэслэл нь ойлгомжгүй, тодорхой бус байдаг тухай асуудал юм. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль хэрэгжиж эхлэхээс өмнө Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн шүүгчид нэр дэвшигч нартай ярилцлага хийхгүй, зөвхөн Мэргэшлийн хорооны үнэлгээгээр тэнцсэн нэр дэвшигчдээс “нууц санал хураалт”-ын үр дүнгээр сонгодог байсан. Энэ байдлыг өөрчлөх зорилгоор буюу Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчтэй ярилцлага хийдэг (ядаж ямар хүнийг Ерөнхийлөгчид санал болгох талаараа мэдээлэлтэй байх үүднээс) зохицуулалтыг бий болгосон.

Харин Шүүхийн ерөнхий зөвлөл энэ дүгнэлтийг ямар шалгуур, үзүүлэлтэд үндэслэж гаргах талаар хуульд тодорхой зохицуулаагүйгээс уг дүгнэлтийн үр дагавар тодорхойгүй үлдэж Ерөнхийлөгчид санал болгох шүүгчид нэр дэвшигчийг сонгох ажиллагаа Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн үзэмжид хэт тулгуурласан шинжтэй хэвээр байна. Гэтэл хуулийн төсөлд уг асуудлыг тодорхой болгох талаар зохицуулалт оруулаагүй, харин ч Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгчид нэр дэвшигчтэй хийдэг ганцаарчилсан ярилцлагыг тусгаагүй нь учир дутагдалтай байна.



**Санал:** Иймд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Шүүхийн мэргэшлийн хорооны шалгалтад тэнцсэн шүүгчид нэр дэвшигчдээс Ерөнхийлөгчид санал болгох нэр дэвшигчийг тодруулах ажиллагааг тодорхой болгож нарийвчлан зохицуулах.

## **Б. Ерөнхий шүүгчийг томилох журам**

Хуулийн төслийн §19.2.5-д “Шүүгчдийн зөвлөгөөн тухайн шүүхийн Ерөнхий шүүгчид нэр дэвшүүлэх, томилох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх” §36.1-д “Шүүхийн ерөнхий зөвлөл нь Мэргэшлийн хорооны үнэлгээг үндэслэн ..., Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилуулах нэр дэвшигчдээс илээр санал хурааж, олонхын санал авсан хүнийг ..., Ерөнхий шүүгчээр томилуулахаар ... Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ”, §37.5-д “Улсын дээд шүүхээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс, ... гурван жилийн хугацаагаар ... томилох бөгөөд нэг удаа улируулан томилж болно” хэмээн Ерөнхий шүүгчийг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс шууд томилох, эсхүл сонгон шалгаруулалт явуулж Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналаар Ерөнхийлөгч томилох юм шиг зөрчилдсөн заалтууд тусгажээ.

Ерөнхий шүүгчийг томилох, сонгох журам улс бүрд харилцан адилгүй байдаг. Манай улсын хувьд 1993 оноос хойш Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг бусад шүүгчийн нэгэн адил сонгон шалгаруулж Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор Ерөнхийлөгч томилж ирсэн. Гэхдээ энэ нь Үндсэн хуулийн шаардлагын хүрээнд эдгээр шүүхийн Ерөнхий шүүгчийг Ерөнхийлөгч ийнхүү томилж байсан хэрэг биш юм. Учир нь Үндсэн хуульд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг хэрхэн ямар хугацаагаар томилох талаар заасан байдаг ба бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг хэн томилох (сонгох), түүний бүрэн эрхийн хугацааны талаар зохицуулаагүй байдаг. Үүнийг 1993-2013 оны Шүүхийн тухай хуульд зааснаар Ерөнхий шүүгчийн бүрэн эрхийн хугацаа 6 жил, нэг удаа улиран томилогдох боломжтой байсан бол 2013 оноос хойш (Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль хэрэгжиж эхэлснээр) Ерөнхий шүүгчийн бүрэн эрхийн хугацаа 3 жил, нэг удаа улируулан томилж болохоор зохицуулснаас бас харж болно.

Ерөнхий шүүгч нь тухайн шүүхээ төлөөлөх, тухайн шүүхийн бие даасан, шүүгч нарын хараат бус байдлыг хамгаалах үндсэн үүрэг хүлээж байдгийн хувьд тухайн шүүхийн шүүгч нартаа хүлээн зөвшөөрөгдсөн, олонхын санал авсан шүүгч байх нь зүйтэй. Бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор Ерөнхийлөгч томилдог байх нь Ерөнхийлөгчийн институцийн зүгээс шүүхэд нөлөөлөх боломжийг улам нэмэгдүүлэх эрсдэлтэй байдаг. Нөгөөтээгүүр, 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсгийг “Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн энэ зүйлд заасан хүрээнд хуулиар олгож болно” гэж өөрчлөн найруулсан ба үүгээр Ерөнхийлөгч Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн дагуу шүүгч болон Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг томилох ба харин бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг томилох эрх хэмжээг өөр хуулиар Ерөнхийлөгчид олгох боломжгүй.

**Санал:** Хуулийн төслийн §19.2.5-д “тухайн шүүхийн Ерөнхий шүүгчид нэр дэвшүүлэх, томилох” гэснийг “нэр дэвшүүлэх” гэснийг хасах;

Хуулийн төслийн §36.1-д “Шүүхийн ерөнхий зөвлөл нь Мэргэшлийн хорооны үнэлгээг үндэслэн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилуулах нэр дэвшигчдээс илээр санал хурааж, олонхын санал авсан хүнийг шүүгч, Ерөнхий шүүгчээр томилуулахаар ажлын таван өдрийн дотор Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ” гэдэг заалтаас “Ерөнхий шүүгчийн, Ерөнхий шүүгчээр” гэснийг хасах.

## **В. Шүүхийн мэргэшлийн хорооны үнэлгээ гаргах хугацааг уртасгах**

Мөн Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн §12.1-т Шүүхийн мэргэшлийн хорооны үнэлгээ гаргах хугацааг 14 хоногоор тогтоосон байдаг ба хуулийн төслийн §88.1-д тусгаснаар Шүүхийн мэргэшлийн хорооны дүгнэлт гаргах хугацааг мөн адил 14 хоногоор тогтоожээ. Уг хугацаанд Шүүхийн мэргэшлийн хорооноос шүүгчид нэр дэвшигчийг сайн судлах, ялангуяа түүнийг хүнийх нь хувьд буюу ёс зүй, зан төлөвийг нь судалж бодит үнэлгээ гаргах боломж хомс байдаг. Үүнийг Шүүхийн мэргэшлийн хорооны гишүүдэд ч хүлээн зөвшөөрдөг.

**Санал:** Иймд Шүүхийн мэргэшлийн хорооны үнэлгээ өгөх хугацааг уртасгах.

## **Гурав. ШҮҮГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ, ТОМИЛОЛТООРАЖИЛЛУУЛАХ**

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд шүүгчийг шилжүүлэн томилох, сэлгэн ажиллуулах гэсэн ойлголтууд хуульчлагдсан боловч эдгээр ажиллагааны ялгаа, үр дагаврыг зааглаж зохицуулаагүй байдаг. Харин хуулийн төсөлд үүнийг дараах байдлаар тусгажээ:

### **Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн төсөл**

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.5. “шүүгчийг сэлгэн ажиллуулах” гэж шүүгчийн мэргэжил, ур чадварыг сайжруулах, шүүн таслах ажлын дадлага эзэмшүүлэх, туршлага судлуулах, шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, шүүхийн хүний нөөцийг оновчтой байршуулах зорилгоор өөрийнх нь зөвшөөрлийг үндэслэн шүүгчийг адил шатны өөр шүүхэд ажиллуулахыг;

3.1.6. “шүүгчийг шилжүүлэн ажиллуулах” гэж шүүхийг татан буулгах, өөрчлөн зохион байгуулах болон энэ хуульд заасан бусад тохиолдолд шүүгчийг өөрийнх нь зөвшөөрлийг үндэслэн адил шатны шүүхэд шилжүүлэн ажиллуулахыг.

16.5. Анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч адил шатны өөр шүүхэд томилолтоор ажиллаж болно. Томилолтоор ажиллах нийтлэг журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална.

43.3. Шүүгчийн хараат бус байдлыг дараах баталгаагаар хангана:

43.3.5. шүүхийг татан буулгасан, өөрчлөн зохион байгуулсан, аль нэг шүүхийн шүүгчийн орон тоо цөөрсөн тохиолдолд Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчийн өөрийнх нь саналыг үндэслэн орон тоо дутуу байгаа адил шатны шүүхэд, адил шатны шүүхэд орон тоо байхгүй бол доод шатны шүүхэд шилжүүлэн томилуулах;



---

43.5. Шүүгчийн мэргэжил, ур чадварыг сайжруулах, шүүн таслах ажиллагааны дадлага эзэмшүүлэх, туршлага судлуулах, шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, шүүхийн хүний нөөцийг оновчтой байршуулах зорилгоор шүүгчийн өөрийнх нь зөвшөөрлийг үндэслэн шүүх хооронд сэлгэх буюу шилжүүлэн ажиллуулж болно.

49.8. Шүүгчийг орон нутагт шилжүүлэх ажиллах болон сэлгэн ажиллуулах тохиолдолд орон байраар хангана.

---

Төрийн албаны тухай хуулийн §44.1-д “Албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн төрийн жинхэнэ албан хаагчтай тохиролцож, эсхүл тухайн байгууллагад 10 ба түүнээс дээш жил нэг албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчийг удирдлагын санаачилгаар төрийн албаны нэг байгууллагаас нөгөө байгууллагад тэдгээрийн удирдлагын хооронд харилцан тохиролцсоны дагуу шилжүүлэн ажиллуулж болно”, §44.2-т “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөрийнх нь зөвшөөрснөөр төрийн байгууллага буюу тухайн байгууллагын нэгж хооронд тэдгээрийн удирдлагын харилцан тохиролцсоны дагуу ажлын тодорхой чиглэлээр 2 жил хүртэл хугацаагаар сэлгэн ажиллуулж болно. Хэрэв төрийн албан хаагч өөрөө буюу түүнийг сэлгэн ажиллуулж байгаа байгууллага хүсвэл анх илгээсэн төрийн байгууллага болон өөрийнх нь зөвшөөрснөөр сэлгэн ажиллуулах хугацааг 1 жил хүртэл хугацаагаар сунгаж болно”, §44.4-т “Энэ хуулийн 44.2-т заасан албан хаагчийг сэлгэн ажиллуулах хугацаа дуусмагц түүнийг урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд нь шууд үргэлжлүүлэн ажиллуулна” гэж “шилжүүлэн ажиллуулах” нь төрийн албан хаагчийг өөр байгууллагад ямар нэгэн хугацаагүйгээр, “сэлгэн ажиллуулах” нь тодорхой хугацаатайгаар өөр байгууллагад ажиллуулах нөхцөлөөрөө ялгаатай байна.

Хуулийн төсөлд ялангуяа нэр томъёоны хэсэгт шүүгчийг шилжүүлэн томилох, сэлгэн ажиллуулах асуудлыг зааглаж тусгасан байх ба харин төслийн §43.5 дахь хэсгийн зохицуулалтаас үзэхэд шүүгчийг сэлгэн ажиллуулах зорилготой нэгэн адил зорилгоор шилжүүлэн ажиллуулж болохоор, мөн хугацааны асуудлыг тусгаагүйгээс “шилжүүлэн болон сэлгэн ажиллуулах”-ын үр дагавар тодорхойгүй хэвээр байна.

**Санал:** Иймд шүүгчийг сэлгэн ажиллуулах нь шүүгчийг шилжүүлэн томилохоос хугацаагаараа ялгагддаг байхаар тусгах, үүнд Төрийн албаны тухай хуульд заасан хугацааг баримталж болох юм. Хэрэв шүүгчийн сэлгэн ажиллуулахад хугацаа зааж өгөхгүй тохиолдолд хуульд “шилжүүлэх ажиллуулах”, “сэлгэн ажиллуулах” гэж ялгаж заах шаардлага үүсэхгүй юм.

Мөн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүгчийг шилжүүлэн болон сэлгэн ажиллуулах саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэхдээ баримтлах журам, шалгуур (ажилласан жил, шийдвэрийн чанар, зөвхөн адил шатны дагнасан шүүхэд хооронд байх гэх мэт)-ыг тодорхой болгох шаардлагатай. Өнөөдөр ялангуяа хөдөө орон нутгийн шүүхээс Улаанбаатар хотод байрладаг шүүхэд шилжиж ажиллах хүсэлтэй шүүгчид цөөнгүй байдаг ба уг асуудлыг шийдвэрлэх журам, шалгуурыг тодорхой болгохгүй бол шүүгчийн энэхүү хүсэл, сонирхолд нь тулгуурласан зүй бус нөлөөллийг бий болгох эрсдэлтэй байдаг.

Хуулийн төслийн §16.5-д “Анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч адил шатны өөр шүүхэд томилолтоор ажиллаж болно. Томилолтоор ажиллах нийтлэг журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална” гэж тусгажээ. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд шүүгчийг томилолтоор ажиллуулахыг нарийвчлан зохицуулаагүй. Харин Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2016 онд Шүүгч томилолтоор нийтлэг журмыг баталсан ба уг журмыг 2018 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр шинэчлэн баталсан. Уг журмын 2.1-д “ ... шүүн таслах ажиллагааг хуульд заасан дэг журам, хугацааны дагуу явуулах нөхцөлийг бүрдүүлэх, шүүхийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор шүүгчтэй зөвшилцсөний үндсэн дээр түүний гаргасан хүсэлтийн дагуу 1-3 сарын хугацаанд адил шатны шүүхэд томилолтоор ажиллуулж болно. Энэ тохиолдолд Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоол гаргана”, 2.8-д “... Томилолтоор ажиллах хугацааг зөвхөн нэг удаа 1-3 сарын хугацаанд сунгаж болно” гэж заажээ. Энэ үндэслэлээр шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шийдвэрээр томилолтоор ажиллуулах нь “шүүгчийг сэлгэн ажиллуулах”-аас ямар ялгаатай байх вэ гэдэг нь тодорхойгүй байна.

**Санал:** Шүүгчийг томилолтоор ажиллуулах нь сэлгэн ажиллуулахаас ямар ялгаатай болохыг тодорхой болгох. Шүүгчийг Ерөнхийлөгчийн зарлиггүйгээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн шийдвэрээр өөр шүүхэд тодорхой хугацаанд томилолтоор ажиллуулах нь Үндсэн хуульд нийцэх эсэхийг эргэн харах.

## **Дөрөв. ШҮҮГЧИЙН БҮРЭН ЭРХ ДУУСГАВАР БОЛОХ**

Хуулийн төслийн §58.1-д “Шүүгч хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны журам болон хуулийн тодорхой заалтыг ноцтой зөрчсөн, хуулийг илтэд буруу хэрэглэсэн бол тухайн шүүгчийн мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварт дүгнэлт гаргуулахаар давж заалдах болон хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн тогтоол гаргаж, Мэргэшлийн хороонд хүргүүлнэ” гэж тусгасан байх ба “ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшнээр шүүгчийн албан тушаалд тэнцэхгүй талаар Мэргэшлийн хорооны дүгнэлт гарсан” тохиолдолд шүүгчийн бүрэн эрхийг дуусгавар болгохоор хуулийн §41.2.10-т тусгасан нь шүүгчийн хараат бус байдлын зарчимтай нийцэхгүй байна.

Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын талаарх НҮБ-ын үндсэн зарчмын (1985) 19 дэх хэсэгт зааснаар «Шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах, албан үүргээс нь түдгэлзүүлэх, огцруулахтай холбогдсон үйл ажиллагааг шүүгчийн ёс зүйн тогтоосон стандартын дагуу явуулна», 20 дахь хэсэгт зааснаар «Сахилгын шийтгэл оногдуулах, албан үүргээс нь түдгэлзүүлэх, огцруулах шийдвэрийг бие даасан хяналтын байгууллага гаргана».

Түүнчлэн, Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчим (2002)-ын 1.4-т «Шүүгч нь албан үүргээ гүйцэтгэж, төвийг сахин шийдвэр гаргахдаа бусад шүүгч, шүүхийн ажилтнаас хараат бус байна» гэж, түүний тайлбарын (2007) 39 дэх хэсэгт шүүгч нь бусад шүүгчээс хараат бус байх ёстой бөгөөд «...шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал нь гаднын зохисгүй нөлөөнөөс ангид байхаас гадна, бусад шүүгчийн үйлдэл, зан төлөвийн зохисгүй нөлөөнөөс ангид байхаас хамаардаг...», 40 дэх хэсэгт шүүхийн шаталсан тогтолцоо нь шүүгчид нөлөөлөх ёсгүй бөгөөд

«Шүүгч аливаа хэргийг шийдвэрлэхдээ давж заалдах тогтолцооны нөлөөнөөс ангид байна, ... шүүхийн шаталсан тогтолцоо болон ямар нэгэн төвшин, зэрэглэлийн ялгаа нь шүүгч шийдвэрээ чөлөөтэй, гаднын үзэл бодол, бусдын нөлөөнд авталгүйгээр гаргах эрхэд халдах арга зам байх ёсгүй» гэж тус тус заасан.

2002 оны Шүүхийн тухай хуульд дээрхтэй ижил утга бүхий заалт байсныг шүүгчийн хараат бус байдлын зарчмыг зөрчиж байна хэмээн үзэж 2012 онд Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийг батлахдаа уг зохицуулалтыг оруулаагүй, харин олон улсад нэгэнт тогтсон “шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааг үнэлэх” талаар хуульчилсан боловч уг үнэлгээний зорилго, зарчмыг сайтар судалж, хуульд тодорхой тусгаагүй, тодруулбал уг үнэлгээний үр дүнд шүүгч цалингийн нэмэгдэл авах зэргээр ялгаварлал, зэрэглэл шүүгч нарын дунд бий болгох, түүнчлэн нэг л удаа хангалтгүй үнэлгээ авсан тохиолдолд тухайн шүүгчийг албан тушаалаас нь огцруулах үндэслэл болгохоор зохицуулсны улмаас Үндсэн хуулийн зөрчлийг бий болгож улмаар холбогдох зохицуулалтуудыг Үндсэн хуулийн цэцээс Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэлт гарсан байдаг.

**Санал:** Хуулийн төслийн §41 дүгээр зүйлийн §41.2.10 болон §58 дугаар зүйлийн §58.1 дэх хэсгийг хасаж, харин үүний оронд хуулийн төсөлд дараах зохицуулалтыг тусгах саналтай байна:

- Шүүгчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ёс зүйн хэм хэмжээг сахих байдал, зан төлөвийг төлөвшүүлэх зорилгоор Шүүхийн мэргэшлийн хорооноос шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааг тодорхой хугацаанд (3-5 жил тутамд) тогтмол үнэлэх;
- Дээрхээс гадна анх шүүгчээр томилогдсоноос хойш хоёр жилийн дараа, Ерөнхий шүүгч, эсхүл дээд шатны шүүхийн шүүгчид нэр дэвшсэн тохиолдолд “шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааг заавал үнэлдэг байх” тэрхүү үнэлгээ нь шүүгчийн сонгон шалгаруулалтын үнэлгээний нэг хэсэг болдог байх;
- Шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны үнэлгээгээр хоёр удаа дараалан хангалтгүй үнэлэгдсэн шүүгчийн асуудлыг Шүүхийн сахилгын хороонд шилжүүлэн шийдвэрлүүлэх механизмыг бий болгох;
- Шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны үнэлгээ хийх журам, шалгуур, үзүүлэлтийг батлах субъектийг заах.

## **Тав. ШҮҮГЧИЙН АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

Хуулийн төслийн §53 дугаар зүйлийн §53.3-т “Шүүгчийн албан тушаалаас огцорсон, эсхүл өндөр насны тэтгэвэрт гарсан бол өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно” гэж заасан байна. Дагаж мөрдөж байгаа Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн §29 дүгээр зүйлийн §29.2-т “Шүүгчид шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдсөн, эсхүл өндөр насны тэтгэвэрт гарсны дараа хоёр жилийн хугацаанд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно” гэсэн хязгаарлалт бий.

Мөн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Албан тушаалтан нь албан үүргээс чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд ашиг сонирхлын зөрчил үүсэж болох үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гээд 21.1.3-т “урьд ажиллаж байсан байгууллагын өмнө аливаа хувь хүн, хуулийн этгээдийг төлөөлөх” гэж хоёр жилийн хязгаарлалтын хугацаа зааж өгсөн.

Түүнчлэн, Ахмад настны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-т “Ахмад настан нийгмийн амьдралд оролцох эрхтэй бөгөөд бие даан, эсхүл ахмадын байгууллага, хууль ёсны төлөөлөгчөөр дамжуулан өөрийн хүсэл, сонирхол, ур чадварт тохирсон хөдөлмөр эрхлэх, үйлчилгээ, тусламж авах, нийгэмд тустай сайн дурын үйл ажиллагаанд оролцож болно” гэж заасан бөгөөд өндөр насны тэтгэвэрт гарсан гэх шалтгаанаар өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхгүй байх гэсэн хязгаарлалт нь иргэний Үндсэн хуулиар олгосон “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох” эрх чөлөөнд халдсан шинжтэй зохицуулалт болсон байна.

**Санал:** Төслийн §53 дугаар зүйлийн §53.3-т “...эсхүл өндөр насны тэтгэвэрт гарсан бол өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно” гэснийг өөрчлөн найруулж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн зохицуулалттай уялдуулах, эсхүл одоо дагаж мөрдөж Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах.

#### ХУУЛИЙН ШҮҮМЖ БОЛОВСРУУЛСАН БАГ:

П.БАТТУЛГА, “Оюуны-Инновац” эрх зүйн судалгааны ТББ-ын судлаач, хуульч

Б.ТӨРБОЛД, “Оюуны-Инновац” эрх зүйн судалгааны ТББ-ын судлаач, хуульч

О.МӨНХСАЙХАН, Хууль зүйн ухааны доктор, МУИС-ийн ХЗС-ийн багш, профессор

А.БЯМБАЖАРГАЛ, Хууль зүйн ухааны доктор, МУИС-ийн ХЗС-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, дэд профессор

Б.ГҮНБИЛЭГ, Хууль зүйн ухааны доктор, хуульч судлаач

Н.БААСАНЖАВ, Монголын хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны тэргүүн, хуульч

П.БАДАМРАГЧАА, Нээлттэй Нийгэм Форумын Эрх зүйн хөтөлбөрийн менежер



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

Жамъян гүний гудамж-5/1  
Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар-14240  
Монгол Улс

Утас: 976-11-313207  
Факс: 976-11-324857  
Вэб: [www.forum.mn](http://www.forum.mn)  
И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)